

Монголын уран зохиол франц хэлнээ

Г. Буяннэмэх /МУИС, ГХСС/

Товч утга: Франц хэлээр орчуулсан Монгол түмний уран зохиолыг аман зохиол, эртний, орчин үеийн уранзохиол хэмээн ангилж нэгэн тойм бүртгэл гаргахаар зорив.

Түлхүүр үг: монгол уранзохиол, ангилал, төрөл зүйл, эх сурвалж, франц орчуулга, судлагаа.

Монгол түмний утгазохиолын баялаг өв сангаас халх, баруун монгол, ордос, халимаг угсаатны уранзохиолын франц орчуулгыг боломжийн хирээр эрэн сурвалжилсанаа энэ удаа бүртгэн оруулсан авч бид эс олж үзсэн, дурдалгүй орхисон зүйл байхыг үгүйсгэх юун.

Бидэнд буй материалаас үзэхэд ХХ зууны эхэн үеэс франц хэлтэн монголч эрдэмтэд³³ монгол уранзохиолыг цуглуулах, эмхэтгэх, судлах, франц хэлээр орчуулах үйлсийн гарааг эхлэн³⁴ өртөөлсөөр иржээ.

Монголч эрдэмтэн Франсуаз Обен *Орчин үеийн хоёр шүлэг /Deux poemes d'aujourd'hui* гэдэг өгүүлэлдээ Д.Нацагдоржийн *Миний нутаг / Ma patrie* шүлгийн сүүлийн 4 бадаг, Ц.Дамдинсүрэн гуайн *Үүл / Nuage* шүлгийн эхний 4 бадгийг францаар орчуулан, *Монголын эртний уранзохиол / L'ancienne littérature mongole* гэсэн өгүүлэлдээ *Заан оготоно хоёр / L'éléphant et la souris*, *Шидэт өвгөн / Le vieux magicien* гэсэн хоёр үлгэрийг орчуулан хавсаргаж 1965 онд хэвлүүлжээ.³⁵

Угсаатны зүйч, хүмүүн судлаач Профессор Роберт Амайон *Шаалайн бүүвэй*³⁶ гэсэн 5 мөрт 3 бадаг бүүвэйн дуу, бадаг бүрт холбогдох домог, үлгэр, халх ардын 3 мөр бүхий 6 бадаг *Эхийн ерөөл / Vœu-bénédictio maternelle*, баяд ардын 3 мөрт 3 бадаг *Эхийн дуу / Chant maternel*, буриад ардын 4 мөрт 4 бадаг *Өлгийн дуу / Chant de berceau*, 37 зүйл

³³ Бельгийн монголч эрдэмтэн, санваартан А. Мостаэрт 1905-1925 онд Ордост байхдаа Ордос түмний аман зохиолын баялаг хэрэглэгдэхүүнийг цуглуулан эмхэтгэж, 1937 онд Бээжин хотноо **Textes oraux ordos** нэртэйгээр хэвлүүлжээ.

³⁴ Францын нангиадч, монголч эрдэмтэн Поль Пеллио Монголын нууц товчооны I-VI бүлгийг францаар орчуулан 1949 онд Парист хэвлүүлжээ.

³⁵ **Шинэ ардчилал** хэмээх сар тутмын сэтгүүлийн 1965 оны X сарын **La seconde йорüe mongole** нэртэй тусгай дугаар, 129- 137, 140 дүгээр тал. Сайхь дугаар нэгэнт ховордсон, эс олдох болсон учир Доктор, Профессор Цэвэлийн Шагдарсүрэнгийн найрсаг зөвшөөрлөөр хувийнх нь хөмрөгөөс авч ашиглалаа.

³⁶ Р. Амайон, **Монгол ардын бүүвэйн дуу**, Монголын судлал, I дэвтэр, 1970, 91-127 дугаар тал.

ертөнцийн гуравыг³⁷ франц хэлнээ тус тус орчуулсан ажээ. Мөн Бэгзийн Явуухулан гуайн *Бугын жим / La sente du serf* шүлгийг С. Адийхүүтэй хамтран францаар орчуулсан байна. (5:210-213)

Монгол судлаач Намчаа Бассаноф Халимаг ардын *Хавирган, Давсан, Сүрлэн хүү гурав, Үнэг, Хүний биеийн мөч эрхтэн, Богширго* гэсэн дөрвөн үлгэрийг орчуулжээ. (4: 81-89)

1961 онд гарсан *Монголын хошин үлгэр яриа* номоос *Гэнэдсэн бадарч / Le badarçi pris au piuge, Бадарчин/ Le badarçi, Сэтэртэй бадарчин / Le badarçi consacrй, Сахалтай бадарчин/ Le badarçi barbu* гэдгийг судлаач Сара Дарс (Sara Dars) францчилжээ. (4:78-80).

Дээрх монголч нарын орчуулгын бүтээл тэр бүр олдох нь ховор болсон тул энд тоймлон дурдсан болой.

Монгол уранзохиолын франц орчуулгыг: ардын аман зохиол, эртний, орчин үеийн уранзохиолын орчуулга хэмээн ангилав.

I. Монгол ардын аман зохиолын орчуулга

Профессор Алэн Дежак³⁸, Цэгмидийн Сүхбаатар нар орчуулан 1991 онд Парист хэвлүүлсэн 35 үлгэр бүхий *Монгол ардын үлгэрийн түүвэр /Contes et rüicits de Mongolie*, 2010 онд Улаанбаатарт хэвлүүлсэн *Монгол ардын ерөөл билгийн үгээс / Des dülicats formules de souhaits populaires mongols*, Патрик Фишман, Г.Мэнд-Ооёо нарын 2012 онд хэвлүүлсэн 30 үлгэр, домог бүхий *Монгол цэцэн билигт ардын үлгэр / Contes des sages de Mongolie*, А.Мостаэрт гуайн *Ордос аман зохиолын цоморлиг /Textes oraux ordos*³⁹ зэрэг бүтээлийг эх хэрэглэгдэхүүнээр, өмнө дурдсан хийгээд цаашид дурдах бүтээлүүдийг нэмэлт хэрэглэгдэхүүнээр ашиглан халх, баяд, буриад, халимаг болон ордос түмний аман зохиолын орчуулгыг нэгтгэн, А.Мостаэрт гуайн ангилалд үндэслэн аман зохиолын төрөл зүйлээр ангилан гаргахыг хичээлээ. Үүнд:

- Үлгэр, домог, хошин яриа / Contes, Lйgendes, Anecdotes – 145
- Дуу / Chansons– 172
- Онъсого, таавар/ Enigmes, Problimes – 200
- Хүүхдийн наадгай/ Jeux d’enfants – 31

³⁷ *Roberte Hamayon, Triades de l’univers, Etudes mongoles, Cahier 3, 1972, pp. 225-238.*

³⁸ *Хөгжим судлаач Лиллийн Их сургуулийн профессор Алэн Дежак монгол багш, орчуулагч нартай хамтран Монгол ардын аман зохиол хийгээд монголын эрт, эдүгээгийн уранзохиолын олон бүтээлийг франц хэлнээ орчуулсан, Монгол судлалд өөрийн байр суурьтай эрдэмтэн юм.*

³⁹ *Antoine Mostaert, Folklore ordos (Traduction des Textes oraux ordos), - Monumenta Serica, Monograph XI, Peip’ing, 1967 [605 pp.].*

- Адис, ерөөл, даллага, шившлэг, маань тарни / Formules de бийdictions, formulas de dalalgha, formulas conjuration, formulas de serment impicatoire; Oraisons jaculatoire – 94
- Элэглэл, тохуурхал, хараал үг / Railleries, Maldictions, Injures– 5
- Сургаал, зүйр, цэцэн үг болон төрөл бүрийн үг хэллэг /Sentences, Dictions, Proverbes, maniire de parler diverses – 562 гэсэн

тоон үзүүлэлт тус тус гарч байгаагаас үзэхэд монгол ардын аман зохиолоос франц хэлнээ орчуулсан нь бас ч чамлахааргүй мэт.

Энэ тухайд Профессор Ц.Сүхбаатар, Ален Дежак нарын орчуулсан *Монгол ардын ерөөл билгийн үгээс / Des délicats formules de souhaits populaires mongols* хэмээх бүтээлд *адуу манах, услах, хариулах, морь уургалах, бугуйлдах, хурдан морь сойх, хөлслөх* г. м. адуу, морьтой холбоотой 58 мөр, *азарга, буур, бух, хуц, ухна тавих* зэрэг эцэг мал тавих, хөнгөлөх үед хэлэх ерөөл 64 мөр, *хонь хяргах, тэмээ ноослох, сарлагийн саваг авах* зэрэг малын ноос авах, зоос савах, эсгий хийх үед хэлэх 38 мөр үг, *арьс сур элдэх, чөдөр ногт зангидах, юм оёх, тогоо нэрэх г.м.* аливаа үйл хийх, аян жинд явахад хэлэх ерөөл 60 мөр, *бэр гуйх, шинэ хувцас өмсөх, гүүний үрс гаргах, гал тахиx, домнох* г. м. зан үйлийн холбогдолтой 128 мөр ерөөл, нийтдээ 63 зүйлийн 348 мөр ерөөл билиг үгийг монгол, францаар харгалдуулан тавьсан байгаа нь нэн сонирхолтой бөгөөд сургалт, судлагааны хэрэглэгдэхүүнээр ашиглах боломжтой юм.

Laure de Cazenove et Odile Weuleresse, *Treize contes de l'Empire Mongol*, 1998 /Лор де Казенов, Одиль Велрес, *Монгол гүрний үеийн 13 үлгэр/* гэсэн ном livre.fnac.com сайтад байна. Эдгээр үлгэрийг нэгбүрчилэн үзэх боломжгүй байсан учир үлгэр, домгийн орчуулгад оруулан тооцоогүй.

2. Монголын эртний уран зохиолын орчуулга

а. Монголын нууц товчоон.

Монголын түүх, уран зохиолын яндашгүй гайхамшигт энэ бүтээлийн франц орчуулга хоёронтоо гарчээ.

Эхнийх нь 1949 онд Парис хотноо хэвлэгдсэн нангиадч, монголч эрдэмтэн Поль Пеллиогийн *Монголын нууц товчоон*-ы эхийн латин сийрүүлэг, I-VI бүлэг буюу 185 дугаар зүйлийн орчуулга юм.

Хоёр дахи нь монголч эрдэмтэн Мари-Доминик Эвен, Родика Поп нарын *МНТ*-ы бүрэн орчуулга бөгөөд 1994 онд Парист хэвлэжээ.

Бельгийн монголч эрдэмтэн Антуан Мостаэртийн *Sur quelques passages de l'Histoire secrute des Mongols*, Cambridge, Massachusetts, 1953 хэмээх номыг МНТ-ы судлалаар гарсан хамгийн жинтэй бүтээл гэж эрдэмтэн судлаач нар үздэг билээ.⁴⁰

Мөн Франсуаз Обен гуайн өгүүлэлд цомхон ч нягт санаа оноотой *L'histoire secrute, ou l'ypopïe de Gengis-khan* гэсэн хэсэг буй. (12:130-132)

МНТ-ы франц орчуулгаар гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын олон бүтээл гарч эрдэм шинжилгээний эргэлтэнд нэгэнт орсон тул үүгээр хязгаарлав.

Харин сүүлийн үед манайд гарч эхэлсэн энэ чиглэлийн судлагааны зарим бүтээлийг дурдвас Г.Цэвэлсүрэнгийн *МНТ-ы зүйрлэл, адилтгалыг франц хэлнээ орчуулсан онцлог* сэдэвт Ph. докторын диссертаци (2006), Т.Сая-Эрдэнийн *МНТ-ы хүний нэрийн зүйлийн франц орчуулгад хийсэн ажиглалт, судлагаа* сэдэвт магистрын дипломын ажил (2007) Г.Цэвэлсүрэнгийн *МНТ-ы хэлний зүйрлэлийн уран хэрэгсэлийг франц хэлнээ орчуулсан онцлог* (ХИС, 2005), *МНТ-г франц хэлэнд орчуулсан нь* (МУИС, ОУХС 2008), Н.Мөнхийн *МНТ-ы čigidei yadir хэмээх үгийн орчуулгын тухайд* (ГХСС, 2010), *Вүрте-činō, Qo'ai taral хэмээх хоёр нэрийн франц орчуулгад хийсэн ажиглалт* (2011), *МНТ-ы франц орчуулга дахь зарим нэрийн тухайд* (2012), *МНТ-ы –жин дагавараар төгссөн хүний нэрийн франц орчуулга* (2013) зэрэг өгүүлэл гарчээ.

б. Гэсэрийн тууж

Профессор Алэн Дежак, Цэгмидийн Сүхбаатар нарын *La geste de Ghesar* гэсэн бүтээл 1991 онд хэвлэгдсэн бөгөөд энэ нь 1716 онд Бээжин хотноо хэвлэгдсэн монгол эхийг баримталсан 8 хэсэг бүхий товч орчуулга юм. Товч орчуулга гэсэн тухайд Ц.Дамдинсүрэн гуайн ... *Объем этого эпоса очень велик. Исполнение его сказителями длится иногда в течение недели и даже нескольких недель. Имеются сведения о том, что полная версия тибетской Гэсэриады состоит 16 томов. ... Буриатская версия Гэсэриады, записанная в начале XX в., включает 20 или 30 тысяч стихов...* гэдгийг үзнэ үү (16:5-6).

Гэсэрийн тууж-ийн энэ франц орчуулгаар хийсэн судлагаа хараахан гараагүй бололтой.

в. Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шашдир

Профессор Ц.Сүхбаатар Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос 1982 онд хэвлэсэн *Монголын уран зохиолын дээж зуун билиг оршив* бүтээлээс монгол эхийг бэлтгэн орчуулж хоёронтаа хэвлүүлжээ.

⁴⁰ А. Мостаэрт гуайн уг бүтээлийн монгол орчуулгыг Антоон Мостаэрт монгол судлалын төв эрхлэн *Монголын нууц товчооны зарим хэсгийн тухай нэртэйгээр* 2010 онд Улаанбаатар хотноо хэвлүүлэв. Эл орчуулгын VII- XVI талаас Ё. Жанчив агсаны бичсэн Ерөнхий редакторын үгийг үзнэ үү.

1995 онд хэвлэгдсэн *La logomachie d'un orphelin vis-a-vis de neuf grands officiers de Ginggis khan* хэмээх эхний орчуулгыг хийхдээ франц хэлтэн Мутомба Мукэнгатай хамтран ажиллажээ.

Хоёр дахи нь *Dispute entre un orphelin et neuf grands officiers de Tchinggis khan* гэсэн гарчигтай гарчээ. (13:28-39)

г. Чингисийн хоёр эр загалын тууж

н. А.Мостаэрт уг туужийн нэгэн хувилбарыг *Чингис хааны хоёр загал* нэрээр тэмдэглэн авч Ордос аман зохиолын бичвэрийн⁴¹ 66-д оруулсан байна. (17:162-167)

д. Оюун түлхүүр

Монгол уран зохиолын дээж зуун билиг оршив бүтээлээс монгол эхийг бэлтгэн Профессор Ц.Сүхбаатар, Алэн Дежак нар орчуулжээ.

Монгол, франц хоёр эрдэмтэн оюун бодлоо ширээн хийсэн 440 мөр энэ орчуулгыг зэрэгцүүлэн үзвээс нэн тустай гэж бодогдном.

... *Өдөр явсан явдлыг шөнө шүүгтүн, La nuit pensez a ce que vous avez fait la veille.*

Ичгүүр гэмт явдлыг ялгаж орхигтун. Renoncez a toute affaire honteuse,

Олны дотор үгээ бэхэл. En sociütü gardez votre langue.

Ганцаар суухдаа сэтгэлээ шинжил ... Lorsque vous ktes seul analysez vos sentiments ...

гэсэн 4 мөрийн орчуулгаас л харахад монгол эхийн утгыг франц хэлнээ сайтар оноон буулгасан нь харагдана.

е. Алтан сургаал

Ишданзанванжилтаны *Алтан сургаал /Le précepte d'or* бүтээлээс 50 мөрийг Бямбын Ринчин гуай утгачилан орчуулжээ. (12:51)

3. Орчин үеийн уран зохиолын орчуулга

Орчин үеийн монгол уран зохиолын франц орчуулгыг эрэн сурвалжилж цуглуулсан цөөвтөр хэрэглэгдэхүүнээ шүлэг, яруу найраг, өгүүллэг, роман гэж ангиллаа.

⁴¹ Ордос аман зохиолын бичвэрийн франц орчуулга 1967 онд Бээжинд гарсан байна. *Folklore Ordos (Traduction des textes oraux ordos), -Monumenta Serica, Monograph XI, Peip'ing, 1967 [605 pp]* хэмээх франц орчуулга тэр бүр олдоогүйгээс эхтэй нь тулган үзэж эс чадав.

а. Шүлэг, яруу найраг

Ази-Африкийн зохиолчдын байнгын хороо эрхлэн англи, франц, араб хэлээр гаргадаг улирал тутмын *Lotus* сэтгүүлд монгол зохиолчдын бүтээлийг 1960-аад оны сүүлээс орчуулан хэвлэх болжээ. (7:18)

Монголын зохиолчдын Хороо Д.Нацагдоржийн *Од* шүлэг, *Ламбугайн нулимс* өгүүллэгийн орос, англи, франц, герман орчуулгыг нэгтгэн 1976 онд хэвлүүлжээ. (19:14, 47-52).

Д.Нацагдоржийн *Дөрвөн цаг: Хавар, зун, намар, өвөл; Од*, Б.Явуухулангийн *Би хаана төрөө вэ, Алаг дэлхийд төрсөн минь учиртай, Эх нутгийн уянга, Мөнгөн хазаарын чимээ, Сохор зоосны дууль* гэхчилэн 37 шүлэг, яруу найргийн монгол эх, С. Адийхүү агсаны франц орчуулгыг харгалдуулан *Монголын яруу найргийн дээжис / Recueil des poemes mongols* гэсэн номыг 2011 онд Доктор Б.Алтангүл эмхэтгэн гаргасан нь орчин үеийн монгол уранзохиолын франц орчуулгаар гарсан тоймтой нэгэн бүтээл болсон байна.

Б.Явуухулангийн *Бугын жим* шүлгийн С.Адийхүүгийн, С.Адийхүү, Роберт Амайон нарын гэсэн хоёр орчуулга байна. (15:118-123, 5:210-213)

Д.Нацагдоржийн *Миний нутаг* шүлгээс хэсэгчилсэн 2 орчуулга байна. Эхнийх нь өмнө бидний дурдсан Франсуаз Обений, хоёр дахи нь англи хэлээс дам орчуулсан Э.Дюпа (E. Dupas)-гийн Хэрлэн, Онон, Туулын ... гэдгээс эхэлсэн 3 бадгийн орчуулга гарчээ.⁴²

Эдгээр шүлэг, яруу найргийн 90 гаруй хувийг С.Адийхүү гуай орчуулан, монголч эрдэмтэн Роберт Амайон хянан тохиолдуулжээ.

б. Өгүүллэг

Бидний суран сурвалжилсанаар Монгол зохиолчдын цөөн хэдэн өгүүллэгийг францаар орчуулсан байна. Үүнд:

Д.Нацагдоржийн *Ламбугайн нулимс /La larme d'un vénérable lama, Цагаан сар ба хар нулимс /Le Nouvel an et les larmes amures* гэсэн хоёр өгүүллэгийг С.Адийхүү, *Хуучин хүү / Le fils du vieux monde*⁴³ өгүүллэгийг Ц. Бадамханд, Харанхуй хад/*Pierre noire* –ыг⁴⁴ Э.Дюпа (E. Dupas) , Д.Цэвэгмидийн *Хос тогоруу / Un couple de grues,*

⁴² rue-de-la-poésie.blogspot.com

⁴³ ГХСС-ийн Орчуулгазүйн Профессорын хамтлагаас 2012-2013 оны хичээлийн жилд тус сургуулийн 13 хэлний оюутны дунд Д. Нацагдоржийн *Хуучин хүү* өгүүллэгийн орчуулгаар уралдаан зарласан дүгнэсэн. Франц орчуулгаар тэргүүн байр авсан II ангийн оюутан Ц. Бадамхандын орчуулгыг МУИС, ГХСС, Орчуулга зүй, 2013, № 01, 27-28 талаас үзнэ үү.

⁴⁴ Англиас дам орчуулсан Харанхуй хад өгүүллэгийг <http://poésie-et-racbouni.over-blog.com> –оос үзэх.

Ч.Лодойдамбын *Гэрээслэл / Un témoignage en héritage*⁴⁵ өгүүллэгийг Г.Буяннэмэх нар тус тус францаар орчуулсан байна. (9: 3-25, 27-41).

Сүүлийн үед монголоос францчилсан орчуулгын талаархи судалгаа ховор байгаа авч Б.Алтангүлийн *Д.Нацагдоржийн “Цагаан сар ба хар нулимс” өгүүллэгийн франц орчуулгад хийсэн ажиглалт* (21: 5-), Г.Буяннэмэхийн *Монголоос франц хэлнээ орчуулах асуудлаас* (ГХСС ЭШБ, 2011) гэсэн ганц нэг өгүүлэл хэвлэгдээд буй. Цаашид энэ чиглэлийн орчуулга, судагааны ажил өргөжин гүнгийрнэ гэдэгт бүрэн итгэнэм.

в. Тууж, роман

Монголын зохиолчдын тууж, романы бүрэн шууд орчуулга хараахан гараагүй байна. Харин ... 1970-аад оны үеэс ... эхлэн Б.Ринченгийн *Үүрийн туяа романыг хэсэгчлэн ...* С.Адийхүү францаар орчуулж хэвлүүлсэн байдаг. (21:5) гэсэн мэдээлэл байгаа ч хэд хэдэн шалтгаанаар бид уг орчуулгыг олж үзэж чадсангүй.

Зохиолч Чинагийн Галсангийн монгол ахуй амьдралын сэдэвт германаар бичсэн тууж, романыг францаар орчуулан 1998 оноос хойш хэвлэсэн байна.⁴⁶

Доминик Пети (Dominique Petit)- гийн орчуулгаар:

1. *Vingt jours et un /Zwanzig und ein Tag*, Editions Мйтaий, 1998.
2. *Ciel bleu / Der blaue Himmel*, Editions Мйтaий, 1999, 160 pages.
3. *Le monde gris/ Die graue Erde*, Editions Мйтaий, 2004, 237 pages.
4. *Sous la Montagne blanche / Der weisse Berg*, Editions Мйтaий, 2004, 288 pages.
5. *La fin du chant / L’Esprit des Pйninsules*, 2005,182 pages ;

Изабел Либерийн (Isabelle Liber) орчуулгаар:

6. *L’Enfant йlu /Das Geraubte Kind*, Editions Мйтaий, 2008,
7. *Chaman/ Die Rьckkehr* , Editions Мйтaий, 2012;

Доминик Вотьегийн (Dominique Vauthier) орчуулгаар:

8. *Belek, une chasse dans le Haut-Altan*, L’Esprit des Pйninsules, 2003, 120 pages
9. *La Caravane / Die karawane*, Edition Esprit des Pйninsules, 2006.

⁴⁵ Д. Цэвэгмидийн *Хос тогоруу*, Ч. Лодойдамбын *Гэрээслэл* өгүүллэгийг чадан ядан францчилсаныг Францын монголч эрдэмтэн, хөгжим судлаач Алэн Дежак чинхүү сэтгэлээр хянан засаж, ариутган шүүсэн болой.

⁴⁶ Wikipedia. org. Galsan Cinag.

Ойрын ирээдүйд монгол түмний уранзохиолын франц орчуулга, судалгааны бүтээл олон гарна гэдэгт итгэн, францчилсан монгол ардын үлгэр, домгийн бүртгэлийг энд хавсралтаар оруулав.

ДҮГНЭЛТ

1. Монгол түмний утга, уранзохиолыг францаар орчуулах, судлах үйлсийн гарааг франц хэлтэн монголч эрдэмтэд тавьсан бөгөөд 1960-аад оны дунд үеэс монгол орчуулагч дагнах, эс бөгөөс францын монголч эрдэмтэн, судлаач нартай хамтран орчуулга хийсээр байна.
2. Монгол уран зохиолыг халх, ордос, халимаг, буриад, баяд хэл аялгуунаас ихэнхидээ шууд францчилсан, хаа нэг дам тухайлбал англи хэлээр дамжуулан орчуулсан байна.
3. Ардын аман зохиол хийгээд орчин үеийн уранзохиолын франц орчуулгын зэрэгцүүлсэн судалгаа ховор байна.
4. Бид энэ удаа Антуан Мостаэрт гуайн ордос аман зохиолын баялаг орчуулгаас гадна монгол туургатны 70-аад үлгэр домгийн, ардын билиг ерөөлийн 63 зүйл 350 мөрийн, ертөнцийн гурвын 37, халх, баяд, буриад ардын бүүвэйн дуу, эртний уранзохиолын 6, орчин үеийн уранзохиолоос 42 бүрэн хийгээд бүрэн бус яруу найргийн, 6 өгүүллэгийн франц орчуулгыг бүртгэн авав.

Résumé

Nous essayons d'établir un bref répertoire des œuvres littéraires mongoles traduites en langue française, mais notre documentation est parfois déficiente, nous ne voulions citer que les titres de certains œuvres parus dans l'Internet, en les classifiant : la littérature orale populaire, la littérature ancienne et contemporaine.

Hormis la traduction de riches œuvres orales ordos par M. Antoine Mostaert, la traduction de 70 contes et récits, plus de 60 formules de souhaits, de 37 triades de l'univers, des berceuses de l'ethnie bayad, bouriate et khalkha mongol, de 6 sources de la littérature ancienne et celle d'une quarantaine de poèmes, de quelques nouvelles contemporaines étaient recueillis et classifiés.

Ашигласан ном зүй

1. Alain Desjacques et Tsegmidin Soukhbaatar, *La geste de Ghesar*, Casterman, 1991.
2. Alain Desjacques et Tsegmidin Soukhbaatar, *Contes et récits de Mongolie*, © Nathan, Paris, 1991.

3. Antoine Mostaert, *Sur quelques passages de l'Histoire secrète des Mongols*, Cambridge, Massachusetts, 1953.
4. *Йтудес монголы*, Cahier 1, 1970.
5. *Йтудес монголы*, Cahier 2, 1971.
6. *Йтудес монголы*, Cahier 3, 1972.
7. Lotus, index 1968, 1969, 1970
8. Marie Dominique Even et Rodica Pop, *Histoire secrète des Mongols*, Paris, 1994.
9. *Nouvelles des ücrivains mongols*, traduites par Ga. Bouyannemekh , гйдaction et correction par Alain Desjacques, Udam soyol, UB., 2010.
10. Patrick Fischmann et G. Mend-Ooyo, *Contes des sages de Mongolie*, Seuil, 2012.
11. Paul Pelliot, *Histoire secrète des Mongols*, Paris, 1949.
12. *La seconde йpopйе mongole*, numйro spйcial, octobre 1965.
13. Soukhbaatar Ts., *Branche de la sagesse / Оюуны нахиа*, УБ., 2010.
14. Дамдинсүрэн Ц., *Исторические корни Гэсэриады*, Из-во АН СССР, Москва, 1957.
15. *Монголын яруу найргийн дээжис* (Д. Нацагдорж, Б. Явуухулан), орчуулсан С.Адийхүү, хянан тохиолдуулж эмхэтгэсэн Б.Алтангүл, франц хэлний орчуулгыг хянасан Роберт Амайон, Букар Амандин, УБ., 2011.
16. Мостаэрт А., *Монголын нууц товчооны зарим хэсгийн тухай*, УБ., 2010.
17. Мостаэрт А., *Ордос аман зохиолын цоморлиг*, УБ., 2010.
18. Мэнд-Ооёо, *Хөхүүдэй, морин хуурын домог*, Мөнхийн үсэг, УБ., 2012.
19. Нацагдорж Д., *Од, Ламбугайн нулимс*, франц орчуулсан С. Адийхүү, УБ., 19 ?? .
20. *Франц судлал* , № 01, УБ., 2009.
21. *Хэлишинжлэл, Боловсрол судлал, Орчуулгын онол, хэрэглээ*, ЭШХ-ын эмхэтгэл, УБ., 2013, 5- тал.
22. *Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шаштир*, ШУХ-ийн Эрдэм компани, УБ., 1995.

Хавсралт

Үлгэр, домгийн орчуулга:

Алэн Дежсак, Цэгмидийн Сүхбаатар нарын орчуулгаар:

- | | |
|--------------------------------------|---------------------------------------|
| 1. Хөхөө Намжил | Namjil- le-Coucou |
| 2. Чоно, үнэг, зараа гурав | Le loup, le renard et le hйrisson |
| 3. Ямаа чоно хоёр | la chivvre et le loup |
| 4. Туулай дэгддэг болсон нь | Comment les lapins apprirent a bondir |
| 5. Сэцэн, Эрдэнэ хоёр | Sage et Pйcieux |
| 6. Тэмээ үнсэнд хөрвөөх болсоны учир | Pourquoi le chameau se roule dans le |
| cendre | |

7. Хоньчин Боролдой, Хурмаст хоёр	Boroldon le berger et le dieu Khourmast
8. Долоон бурхан	Les sept йтоiles de la Grande Ourse
9. Худгийн мэлхий	La grenouille voyageuse
10. Өнчин цагаан ботго	Le chamelon blanc orphelin
11. Зальтай бадарчин	Le moine dйgourdi
12. Тоть	Le perroquet malicieux
13. Тарвага дөрвөн хуруутай болсон нь	Pourquoi la marmotte n’a que quatre doigts
14. Алтан, Мөнгөн хүү	Fils d’or et Fils d’Argent
15. Морь, чоно, туулай гурав	Le cheval, le loup et le liivre
16. Сарьсан багваахай	La chauve-souris
17. Эвтэй дөрвөн амьтан	Les quatre amis
18. Аргат өвгөн	Contes du vieillard astucieux
19. Хэдгэнэ, хараацай хоёр	Le frelon et l’hirondelle
20. Тэнэг хаан	Le roi qui avait mal a la tkte
21. Хэрэйдийн сэцэн хаан	Le sage roi de Kheredi
22. Тэнэг чоно	Le loup imbйcile
23. Бар судалтай болсон нь	Pourquoi le tigre a la peau rayйе
24. Өдөр унасан махыг авдаггүй	Il ne faut pas ramasser la viande qui tombe a terre
25. Мэргэн харваач	L’habile archer
26. Тэмээ, буга, морь гурав	Le chameau, le cerf et le cheval
27. Ховдог өвгөн	Le mari glouton
28. Ухаант хүү	Les garзons devins
29. Гутал шүтээн болсон нь	Les bottes вйнйгйе
30. Хараацай, үнэг, огтоно гурав	Le rossignol, le renard et la souris
31. Тэнэг агь, ухаант гүнж хоёр	Prince imbйcile, princesse perspicace
32. Үнэг чоно хоёр	Le renard et le loup
33. Мэлхий	La grenouille
34. Цуутын цагаагч гүү	La jument blanche et son poulain
35. Хэцүү	C’est dur

Contes des sages de Mongolie par Patrick Fischmann, G. Mend –Ooyo

1. Туульчийн дуулал	Le chant du barde
2. Хори Түмэд, хун дагины үлгэр	Khori Thumed et la femme-cygne
3. Монголд үлгэр домог үүссэн нь Mongolie	Origine des contes et lйgende de
4. Замбуулингийн үүсэл, галтай болсон нь	La сгйation, le Feu et les Aneux йтойлйs
5. Морин хуурын домог	Morin khuur, la виале a tkte cheval

6. Хулан, хэрээ, чоно гурвын үлгэр	Qui sime le vent
7. Хөхөө Намжил	Namjil, le Coucou
8. Бөртэ чоно, Гоо маралын үлгэр	Les apeuls sacrйs
9. Шаалуу хүүгийн домог	L’histoire du garзon Shalou
10. Эрхий мэргэн	L’archer-marmotte
11. Долоон хожгор, нэг можгор	Sept chauve et un Trapu
12. Хүн гэрэлтэй байсан тухай	La lйgende de la lumiere humaine
13. Хужирт рашаан	La source Khujirt
14. Алтан гадас	L’йtoile d’or
15. Бошлий хад: хүн чулуу болсон тухай	La fille qui devient rocher
16. Болдоггүй бор өвгөн	Vieux-Tannй-Tktu
17. Багц таван мөс	Le faisceau de cinq fliches
18. Тогорууны	L’enfant des grues
19. Мэргэн далны домог	Lйgende de l’omoplate
20. Монгол уртын дууны үүсэл	Origine du chant long mongol
21. Бүүвэйн дууны домог	Lйgende de la berceuse
22. Буга, тэмээ хоёр	Le cerf et le chameau
23. Өнчин цагаан ботго	La complainte du chamelon blanc
24. Цагаан уулын домог	Lйgende de la montagne Blanche
25. Цэцэн хүүгийн үлгэр	L’histoire d’un garзon magicien
26. Морины домог	Le don du cheval
27. Луйварч хааны хувь тавилан	Le destin du roi brigand
28. Бөөгийн дуудлага	Chant de chaman
29. Яруу найрагчийн цадиг	Comment le Khan a choisi le plus grand pontе
30. Жигүүрт морины тухай	Le barde au cheval ailй
31. Хөхүүдэй, морин хуурын домог	Huhuudei, lйgende de Morin Khuur

Сара Дарсын орчуулгаар:

1. Гэнэдсэн бадарч	Le badarči pris au piinge
2. Бадарчин	Le badarči
3. Сэтэртэй бадарчин	Le badarči consacй
4. Сахалтай бадарчин	Le badarči barbu

Франсуаз Обений орчуулгаар:

1. Заан оготоно хоёр	L’йlйphant et la souris,
2. Шидэт өвгөн	Le vieux magicien